

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА





## ХҮМҮҮНЛЭГИЙН ИНТЕРВЕНЦ БА БАЙГАЛИЙН БАЯЛАГ

**Б.Баярцэнгэл\***

***Abstract:** The research is about geopolitical strategy of “One belt, One road” initiative proposed by China. The strategy behind China is giving a great importance to the event is to ensure its energy security. An analysis on the policy implemented by Chinese government through the dimensions of land and water to implement the strategy is conducted. While it is too early to evaluate the whole process of OBOR, China has been taking daring steps to meet the primary strategy of ensuring its energy security. At this rate, it is agreeable that probability of China ensuring its energy security out of control of U.S., nearly one or two decades.*

***Түлхүүр үгс:** Responsibility to protect, Resource Wealth, Humanitarian Intervention*

\* \* \*

“Хүний эрх, ардчилал, эрх тэгш байдал” зэрэг зарчмууд нь орчин үеийн олон улсын хамтын нийгэмлэгийн уриа болж байгаа билээ. Мөн эдгээр концепцуудыг хэрэгжүүлэх, мөрдүүлэх нэг төрлийн хэрэгсэл нь хүмүүнлэгийн интервенц ба хамгаалах хариуцлагын хэрэгжилт юм гэсэн нийтлэг ойлголт олон улсын харилцаанд оршиж байгаа ч хүмүүнлэгийн интервенц ба байгалийн баялгийн (өргөнөөр авч үзвэл аливаа улсын материаллаг ашиг сонирхол) хооронд бүдэг боловч байнга орших уялдаа холбоо, харилцан хамаарал оршсоор байна. Өөрөөр хэлбэр чамин сайхан нэршил, концепцийн цаана хамгийн ердийн эрх ашиг, геополитик, эдийн засаг, улс төрийн бодлого хүмүүнлэгийн интервенцийн үндэс болж байна гэж үзэх үндэслэл байгаа юм. Чухам энэхүү бүдэг уялдаа холбоог энэ өгүүлэлд миний бие судлахаар оролдов. Юуны өмнө хүмүүнлэгийн интервенц нь зөвхөн байгалийн баялгаар баян, зарим тохиолдолд стратегийн баялаг ихтэй бүс, нутагт л маш идэвхтэй хэрэгжиж байгаа нь ажиглагдаж байгаа юм. Энэ байдлыг судлахын тулд хэрэгжиж өнгөрсөн хүмүүнлэгийн интервенцүүдийг олон улсын харилцааны реалист урсгалын дагуу судлах бөгөөд голлон Ливи болон Косовогын жишээн дээр авч үзсэн юм.

Энэ асуудлыг бүхэлд нь авч үзэхийн тулд хэд хэдэн асуулт дэвшүүлж, түүндээ хариулт эрэлхийлсэн юм. Эхний асуулт бол: Хүмүүнлэгийн интервенц гэж юу вэ, түүхэнд хэрхэн хэрэгжиж байв? Дараагийн асуулт: хэзээ, хаана хүмүүнлэгийн интервенц хэрэгжсэн вэ? Эдгээр асуултыг хариултуудыг дор сийрүүлээ.

Саяхныг хүртэл улс орнууд хүмүүнлэгийн интервенцийг олон улсын хууль эрх зүйн бүрэн номлол гэж үздэггүй байв<sup>1</sup>. Хүйтэн дайны үед олон улсын харилцаа

\* МУИС-ийн ОУХНУС-ийн ОУХ-ны тэнхимийн багш

<sup>1</sup> Christine Gray., (2004). International Law and the Use of Force. Oxford University Press. Page 31

Зөвлөлт болон Барууны үзэл суртлын туйлуудад хуваагдсан байсан бөгөөд аль нэг талаас хүмүүнлэгийн интервенц хийх нь өргөн хүрээтэй мөргөлдөөн, дайнд хүргэж болох эрсдэлтэй байжээ. ЗХУ задран унаж хүйтэн дайн төгсгөл болсны дараа л хүмүүнлэгийн интервенц нь олон улсын харилцаанд бүрэн хэрэгжих орчин бүрдэж эхэлсэн билээ. Гэвч хүмүүнлэгийн интервенцийн хууль эрх зүйн үндэслэл нь өнөөдөр ч маргаан дагуулсан хэвээр байгаа юм. 2005 онд НҮБ-аас “Хамгаалах хариуцлага” санаачилгыг байгуулсан нь олон улсын хэмжээнд хүний эрхийг хамгаалах, улс орнууд өөрсдийн иргэдийн өмнө хүлээх хариуцлагыг бэхжүүлэх чухал алхам болжээ.

Өнөөгийн олон улсын харилцаанд хүмүүнлэгийн интервенцийг хэрэгжүүлэх цорын ганц арга бол НҮБ-ын Аюулгүйн зөвлөлөөс мандат өгч зөвшөөрсөн тохиолдолд л хэрэгжих боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл Аюулгүйн зөвлөлийн гишүүд бүгд ашиг сонирхлоо нэгтгэж, санал нэгтгэйгээр дэмжсэн тохиолдолд хүмүүнлэгийн интервенц хийх боломжтой юм. Хүмүүнлэгийн интервенцийн талаар үндсэн хоёр төрлийн бүлэг маргадаг бөгөөд эдгээр нь плюралист ба солидарист нар юм.

Самуэль Хантингтон болон М.Смит тэргүүтэй плюралистууд нь хүмүүнлэгийн интервенцийг үзэхдээ реалист үзэлд тулгуурладаг бөгөөд “улс орнууд хувиа хичээх эгоист үзэлтэй, зөвхөн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх сонирхолтой байдаг” (Brown, 2002, p.136) гэж үзжээ. Плюралистуудыг байр суурийг судалж үзээд судлаач Крис Броун дүгнэхдээ “хүмүүнлэгийн интервенц нь ерөнхийдөө реалист бус үзэл боловч “хүмүүнлэгийн” гэсэн тусгай тодотголтой улс орнуудын төлөв байна гэж үзэх нь олон улсын харилцаанд улс орнуудын биехвиоризм судлалд реалист үзэл давамгайлж байгааг илтгэх бөгөөд (Brown, 2002, p.163) үүнээс улбаалан тэдгээрийн үйл ажиллагаа нь зөвхөн материаллаг ашиг сонирхолд бус харин бусад улс орнуудад хүний амь насыг хамгаалах гэсэн шударга үйлдэл юм” гэж дүгнэсэн байдаг<sup>2</sup>. Гэвч плюралистуудын гол үзэл санаа нь хүмүүнлэгийн интервенцийн гол зорилго нь тухайн улсын үндэсний эсвэл материаллаг ашиг сонирхлыг хамгаалахад суурилсан байх ёстой гэсэн үзэл дээр тулгуурлаж байдаг билээ.

Либералистуудын адилаар солидаристууд үзэхдээ хүмүүнлэгийн интервенц нь олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээх улс орнууд, олон улсын байгууллагуудын олон улсын үүрэг хариуцлага мөн гэж үздэг. Эл үзлийн талаар судлаач Ёоргенсен бичихдээ “...хувь хүн, хүмүүс, болон олон улсын байгууллагууд нь улс орнуудын адилаар олон улсын эрх хамгаалах хариуцлагын нэг хэсэг мөн ...” гэжээ (Knud Erik Jorgensen, 2006, p.159).

Холцгрете болон Кеоханегийн үзлийг цааш дэлгэрүүлж, Рейсман үзэхдээ “хүмүүнлэгийн үүднээс интервенц хийхээр завдаж, улс орнууд ихээхэн ялгавартай хандаж ажиллахын дээр хүмүүнлэгийн бус, өөрийн ашиг сонирхолд тулгуурласан мотивацтай үйл ажиллагаа явуулах нь элбэг байдаг” (J.L.Holzgrete, 2003, p.77). Гэвч дэлхийн үл сэргээгдэх баялаг багасахын хэрээр их гүрнүүд илүү шийдвэртэй алхам хийх болоод байна.

<sup>2</sup> Anthony Joseph., (2010). Humanitarian intervention; Pluralist and Solidarist view. [online] Цахим холбоос: <http://www.anthonijosephreport.com/2010/06/humanitarian-intervention-pluralists.html> [Мэдээг авсан 4 April 2012]

Судан, Сьерра-Леоне, Либери, Ангол, Конго, Камбожид болсон мөргөлдөөнүүд нь хүйтэн дайны дараах улс төрийн эдийн засаг дахь сонирхлыг сэргээсэн бөгөөд эдгээр мөргөлдөөнүүдэд байгалийн баялгийн эзэмшлийн асуудлаас голлон улбаалсан мөн энх тайван тогтооход гол саад учруулагч элемент нь байгалийн баялаг байжээ<sup>3</sup>.

Үүний зэрэгцээ 2001 оны 9-р сарын 11-ний халдлага, терроризмын эсрэг дайн, Иракийн дайнаас үүдэн үүссэн сөрөг уур амьсгал зэрэг нь XXI зууны эхэн үед хүмүүнлэгийн интервенцийн хэрэглээ хамгийн доод түвшинд хүргэсэн юм<sup>4</sup>. Миний үзэж байгаагаар Иракийн дайн нь цэвэр байгалийн баялаг дахь ашиг сонирхолд тулгуурласан бөгөөд “тус улсын Персийн булантай ойр, бүс нутгийн төвд байрлах байршил нь бүс нутгийн хүчний тэнцвэрт чухал нөлөөтэй байсан” (Yergin, 2011, p.146). НҮБ-ын хувьд хүмүүнлэгийн интервенцийн концепц нь Иракийн дайнаас маш өөр байж ирсэн билээ. Тухайлбал, НҮБ-аас интервенц хийхэд цэргийн байлдааны ажиллагааг бууруулах бодлоготой, хэрвээ интервенц хийсэн тохиолдолд цөөн хэдэн улс биш аль болох олон орны цэргээс бүрдэх цэргийн бүрэлдэхүүн оролцохыг баримталдаг байна. Мөн НҮБ-аас хэрэгжүүлж буй интервенц нь мөргөлдөөнийг энх тайван замаар шийдвэрлэхэд түлхүү анхаарч, энх тайвныг цогцоор нь, суурь сайтайгаар тогтоохыг эрмэлздэг. Гэвч одоогоор хэрэгжээд буй интервенцүүдээс аль ч НҮБ-ын дээрх баримтлал, шалгууруудад бүрэн нийцсэн байдлаар явагдаж хэрэгжихгүй байна.

Интервенц хийж цэрэг, танкууд хил давж орсны дараа хэдэн сар, жилээр харилцан адилгүй үр дүн илэрч байдаг тул интервенцүүдийн бүрэн үнэлгээ, судалгааг мөн чанараар нь судалж гаргах боломж хомс байх талтай<sup>5</sup>. 2002 оноос хойш хүмүүнлэгийн интервенцийн номлолын хүрээнд нийт 16 удаа интервенц хийсэн байдаг бөгөөд эдгээр интервенц хийсэн улсуудад хөгжил цэцэглэлт алсарсан зайтай хэвээр байгаа юм.

## Байгалийн баялаг

Дэлхийн газрын баялагт хяналт, саадгүй нэвтрэхийн төлөөх тэмцэл олон улсын тавцанд XXI зуунд улам ширүүсэх төлөвтэй байна<sup>6</sup>. Дэлхийн газрын баялаг аажмаар шавхагдаж эхлэхэд үлдсэн нөөцийг мэдэлдээ авах, эсвэл түүнд ашиг сонирхлоо илэрхийлэх байдал нь улс орнуудын хувьд улам нарийн төвөгтэй хэлбэрт шилжиж байна. Чухамдаа дэлхий нийт Ийстэр буюу Пасхи арлын түүхийг давтах замд орж байна гэж үзэж болохоор байгаа юм<sup>7</sup>. Тийнхүү газрын баялгийн төлөөх ашиг

<sup>3</sup> Karren Ballentine and Jake Sherman., (2003). The Political Economy of Armed Conflict, Beyond Greed and Grievance. London: Lynne Rienner Publishers. Page 167

<sup>4</sup> Thomas G. Weiss., (2012). War and Conflict in the Modern World, Humanitarian Intervention. Polity Press. 2

<sup>5</sup> Bartolome de las Casas, In Defense on Indians (1552), trans, Strafford Poole (DeKalb: Northern Illinois University Press, 1992), 207.

<sup>6</sup> Mehmet Efe Bireselioglu, (2011). European Energy Security, Turkey's Future Role and Impact. [online] Palgrave Macmillan. Available from: <http://www.palgraveconnect.com.ezproxy.westminster.ac.uk/pc/doi/finder/10.1057/9780230306851> [Accessed 2 April 2016].

<sup>7</sup> Researchers believe that Easter Island in the middle of Pacific ocean was once covered with dense forest. As humans inhabited the land gradually forest shrunk and people fought fiercely for the depleting forest. Ultimately it led to the islanders demise.

сонирхлоо нарийн төвөгтэй байдлаар илэрхийлэх үйл ажиллагаа хүмүүнлэгийн эсвэл ардчиллын төлөөх үйл ажиллагаатай холилдож буй нь эдгээрийг ялгаж салгахад нэн төвөгтэй болгож байна.

Дэлхий дээрх газрын баялгаас үүдэлтэй мөргөлдөөнүүдийг жагсаавал асар том жагсаалт гарах болно. Хамгийн энгийн жишээ дурдахад л Персийн булангийн дайн, Каспийн тэнгис орчим дахь эрчим хүчний төлөөх мөргөлдөөнүүд, Өмнөд Хятадын тэнгис дэх газрын тосны төлөөх мөргөлдөөн, Нил мөрний орчим дахь цэвэр усны төлөөх мөргөлдөөн, Иордан, Тигр-Эфрат болон Инд мөрний сав газар дахь усны төлөөх мөргөлдөөн зэрэг маш олон мөргөлдөөнүүдийг нэрлэж болно. Эдгээр мөргөлдөөний аль нь ч тус бүсийн оршин суугчид дунд газар авах, улмаар хэмжээгээ тэлж хүмүүнлэгийн интервенц хийх нэн шаардлагатай нөхцөл байдал үүсгэх боломжтой юм.

АНУ болон түүний холбоотнуудын өрнүүлж буй “Терроризмын эсрэг” дайн нь түүнд оролцогч орнууд аюулгүй байдлын нийтлэг эрсдэлтэй учирсан тохиолдолд шийдвэртэй хамтын арга хэмжээ авах эрмэлзэлтэй байдгийг харуулж байгаа билээ. Энэ эрмэлзэл нь байгалийн баялаг арвинтай улсад дотоодын үймээн самуун үүсэж тогтворгүй болоход илрэх бүрэн боломжтой юм. Дэлхийн ашигт малтмал, байгалийн баялгийн нөөц багасах тусам үймээн самууныг зогсоох, тогтвортой байдлыг тогтоох уриан доор дээр дурдсан эрмэлзлийн биелүүлэх сонирхол, шаардлага улам өсөх магадлалтай болж байна.

Хөгжиж буй, байгалийн баялаг ихтэй орнууд дотоодын тогтворгүй байдал, зөрчилдөөнд өртөмтгий байдаг нь нийтлэг зүйл билээ. Тогтворгүй байдал ч, зөрчилдөөн ч хүний эрхийг зөрчсөн хямрал, иргэний дайнд хүргэж, эрдэс баялгийн эх үүсвэр эрэлхийлэгч орнуудад интервенц хийх шалтаг, шалтгаан өгөх магадлал бий.

Байгалийн баялаг болон иргэний дайныг харилцан хамааралтай болохыг судалсан судалгаа харьцангуй их байдаг. Тухайлбал судлаач Майкл Л.Росс нь 13 кейсд судалгаа хийж тэдгээрээс 8 холбоо хамаарал илрүүлсэн байна. Үүнд:

- 1) Зарим төрлийн байгалийн баялаг, тухайлбал газрын тос, үнэт чулуу, мансууруулах үйлчилгээтэй ургамал иргэний дайн үүсэх шалтгаан болдог;
- 2) Бусад төрлийн анхдагч баялаг, тэр дундаа газар тариалан иргэний дайнд ямар нэгэн байдлаар нөлөөлөөгүй;
- 3) Хамгийн өргөн дурдагддаг 2 нөхцөл (causal mechanisms) механизмуудыг батлах ямар нэгэн хэлхээ, баримт байгаагүй;
- 4) Хууль бус мансууруулах бодис мөргөлдөөн эхлэхэд нөлөөлөөгүй ч өрнөж буй мөргөлдөөнийг сунжруулах, уртасгах нөлөөтэй байсан;
- 5) Салан тусгаарлах мөргөлдөөний 3 тохиолдолд газрын баялаг нь салан тусгаарлах бус шинжтэй 10 мөргөлдөөнөөс ялгаатай нөлөө үзүүлсэн;
- 6) Газрын баялаг мөргөлдөөнийг сунжруулаагүй эсвэл хурцатгаагүй, харин ч зарим тохиолдолд мөргөлдөөнийг богиносгож, дайтагч талуудад хамтын ажиллагаа эхлүүлэх үндэс болж байсан;

- 7) Кейс болгож судалсан ихэнх иргэний дайнуудад байгалийн баялаг нь зэрэгцэн хэрэгжих хэд хэдэн механизмаар дамжин нөлөөлсөн байдаг.
- 8) Кейс болгож судалсан 13 иргэний дайнд хямрал ба баялгийг холбосон урьдчилан таамаглаагүй хэд хэдэн механизм байсан нь: гадаад интервенц, дайны олзыг хуваарилсан гэрээ, хэлэлцээрүүд, мөн баялаг ихтэй нутгуудад урьдчилан хяналт тогтоох зэрэг байв<sup>8</sup>.

1998 онд Ардчилсан Бүгд Найрамдах Конго улсад (хуучнаар Заир) болсон мөргөлдөөн нь дэлхийн II дайнаас хойш олонтаа тохиолдох болсон нарийн төвөгтэй, нийтлэг мөргөлдөөний жишээ юм<sup>9</sup>. Ерөнхийдөө Африк тивд болсон бүх интервенцүүд ямар нэгэн байдлаар газрын баялгаас хамааралтай, түүнээс үүдэлтэй байдаг.

Газрын баялагт холбогдох энэ мэт сөргөлдөөн нь эмзэг эдийн засагтай хөгжиж буй орнуудад голчлон тохиолдож байдаг. Нөгөөтээгүүр Орос, Хятад гэсэн бүс нутгийн их гүрнүүд өөрсдийн байгалийн баялагтай хөрш орнууддаа нөлөөлөх, шахалт учруулахад хэрэглэж байна. Үүнтэй ижил газрын баялаг, түүний түгээлтээр шахалт учруулах гэсэн үйл ажиллагаа нь олон улсын эдийн засгийн гол зохицуулагч орнууд шууд хариу үйлдэл үзүүлэхэд хүргэж болзошгүй үр дагавартай.

## Ливи

2011 онд Ливи улсын дотоодод үүсээд байсан хүчирхийлэл, хямралыг сааруулах, зогсоох зорилгоор үйл ажиллагаа эхлүүлэх НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шийдвэр гарсан нь хамгаалах хариуцлагыг хэрэгжүүлэх үйл хэрэгт шинэ, эрч хүчтэй давалгаа үүсгэсэн юм.<sup>10</sup> Ливийн иргэний дайнд үзүүлсэн Барууны орнуудын дэмжлэгтэй хариу үйл ажиллагаа гайхам хурдан хугацаанд болж өнгөрсөн билээ. Барууны орнууд Ливийн хямралд ийм хурдан хариу үйлдэл үзүүлж эхэлсэн нь Барууны орнуудын хувьд Ливи ямар ач холбогдолтой байсныг харуулж байна. Ливи бол Европын түүхий газрын тос болон газрын тосыг нефтийн бүтээгдэхүүний томоохон хэсгийг нийлүүлдэг баялаг ихтэй улс юм. Үүнээс улбаалан Ливид үүссэн аливаа хямрал удаан хугацаанд үргэлжлэх нь Европын эдийн засгийн тогвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэх байсан тул Франц тэргүүтэй орнууд ийнхүү маш түргэн арга хэмжээ авсан гэж үзэх үндэс байгаа юм. Үүнээс гадна ардчиллыг дэлгэрүүлэх, хамгаалах бодлогын хүрээнд Өрнөдийн орнууд хэдийгээр Каддафигийн засаглалтай найрамдалт харилцаатай байсан ч Ливийн иргэний дайнд босогчдын талыг дэмжиж үйл ажиллагаа явуулсан билээ. Хэрвээ Өрнөдийн орнуудын аюулгүй байдлын орон зай байдаг гэж үзвэл Ливи нь тэр орон зай дотор оршиж байгаа бөгөөд НАТО болон Европын зүгээс энэ орон зай дотор аливаа төрлийн тогтворгүй байдлыг ямар ч тохиолдолд хүлээн зөвшөөрөхгүй юм. Ливийн тогтворгүй байдал эхэлмэгц НАТО-ын зүгээс хариу үйлдэл үзүүлсэн хурд нь үүнийг гэрчлэхээс гадна

<sup>8</sup> Michael L. Ross, (2003). How Do Natural Resources Influence Civil War? Evidence from Thirteen Cases. [Online] Available from: <http://www.sscnet.ucla.edu/polisci/faculty/ross/IO%202004.pdf> [Accessed on 4 April 2012]

<sup>9</sup> Christine Grey., (2004). International Law and Use of Force. Oxford University Press. Page 60.

<sup>10</sup> Thomas G. Weiss., (2012). War and Conflict in the Modern World, Humanitarian Intervention. Polity Press. Page 2

Европын хил дагуух байгалийн баялгийн нөөц бүхий газруудын ач холбогдлыг харуулж байна гэж үзэж байна.

Каддафигийн засгийн газрын үй олноор хөнөөх зэвсгээс татгалзсан, терроризмын асуудлаас зайгаа барьсан бодлогуудаас улбаалан тус улсад тавиад байсан олон тооны хоригуудыг 2003, 2004 онд цуцалсан нь эдийн засгийг чөлөөт болгож, газрын тос болон гадаад хөрөнгө оруулалт нь Ливид шинээр хөрөнгө, хөгжил авчирчээ<sup>11</sup>. Гэвч дотоодын зөрчил хурцдан иргэний дайн эхэлж, хүчирхийлэл газар аван, аль аль талаас хүний эрхийг ноцтой зөрчиж эхэлсэн юм. Энэ нөхцөлд НҮБ, НАТО маш хурдан арга хэмжээ авч, ердөө хэдхэн долоо хоногийн дотор НАТО-ын гишүүн орнуудын нисэх хүчин Каддафигийн талын цэргийн байршлуудад цохилж өгч эхэлсэн юм.

Олон хүчин зүйлүүд энд нөлөөлсөн билээ. Тухайлбал Итали, Их Британийн Ливийн газрын тосон дахь сонирхол, түүнд хүрэх гарц олох сонирхол багагүй нөлөө болсон. Гэвч Каддафигийн дэглэм ч, түүний дараа гарсан дэглэмүүд ч аль аль газрын тосоо худалдахаас төдийлөн татгалзахгүй, харьцангуй нээлттэй худалдаа баримталж байсан тул тус Ливийн иргэний дайнд хийсэн интервенц нь цэвэр газрын тосонд суурилсан ажиллагаа биш байсан юм. Харин НАТО-ын бодлого энэ тохиолдолд ихээхэн нөлөө үзүүлсэн байдаг. Герман интервенцэд оролцохгүй гэж мэдэгдсэн нь Францад энэ талбарт АНУ болон Их Британитай илүү нягт хамтран ажиллах боломж үүсгэсэн. Арабын холбооноос агаарын хориотой бүсийг дэмжиж (удалгүй агаарын хориотой бүсэд холбоотны хүчин агаарын цохилт хийх боломжтойг мэдмэгцээ байр сууриа бүрэн өөрчилсөн) Арабын орнууд хамтран ажиллах боломж санал болгосон байдаг<sup>12</sup>. Хэдэн сарын дараа Каддафигийн дэглэм унаж, НАТО-ын улс төрийн зорилго биелсэн билээ. Франц, Италийн хувьд өөрсдийн өмнөд нутгуудад ирж болзошгүй байсан дүрвэгсдийн асуудлаас урьдчилан сэргийлж чадсан бол удалгүй түр тасалдаад байсан Ливийн газрын тос Европт эргэн нийлүүлэгдэж эхэлсэн юм. АНУ тэр дундаа Обамагийн засаглал олон улсад хүний эрхийг хамгаалах үйлсэд анхаардаг, чармайлт гаргадаг гэдгээ харуулж (интервенцэд хамтран оролцох болсон гол шалтгаан нь ч байж болох магадлалтай), мөн Ж.Бушийн засаглалын үед хийсэн Иракийн дайнаас болж ихээхэн унаад байсан олон улсын нэр хүндээ сэргээж, бэхжүүлсэн юм.

## Косово

Косово дахь интервенц, бөмбөгдөх ажиллагаа нь хүмүүнлэгийн интервенц, байгалийн баялагтай холбогдох эсэх талаар тусгай кэйс болох юм. Яагаад гэвэл Косовогын баялаг нь байгалийг бус стратегийн баялаг байсан (стратегийн баялаг гэж тус бүс нутгийн тогтвортой байдал, аюулгүй байдлын бүрэн бүтэн байдал, Косовогын Европ дахь хайхралгүй өнгөрч боломгүй байрлал зэргийг бүхэлд нь

<sup>11</sup> Blanchard, Christopher M., (2011). Libya: Unrest and U.S. Policy. [online] Congressional Research Service. Available from: <http://www.dtic.mil/cgi-bin/GetTRDoc?AD=ADA543510> [Accessed 3 April 2012] Page 11.

<sup>12</sup> Geroge Friedman., (2011). Libya, the West and the Narrative Democracy. [online] Available from: [http://www.afgazad.com/Zabanhaye-Eropaei/040111-Libya-the-West-and-the-Narrative-of-Democracy\[1\].pdf](http://www.afgazad.com/Zabanhaye-Eropaei/040111-Libya-the-West-and-the-Narrative-of-Democracy[1].pdf) [Accessed on 4 April 2012]. Page 4

хамруулан авч үзэв). Хэрвээ тогтвортой байдал, бүс нутгийн аюулгүй байдлын бие даасан байдал зэргийг газрын баялагтай адилтган баялаг гэж үзвэл Косовод болсон интервенцийг баялагт суурилсан ердийн интервенц хялбархан тайлбарлаж болох юм. Гэвч хүний эрхийг чанд хамгаалах ёстой гэсэн үзэл дэлгэрсэн орчин үеийн олон улсын харилцаанд НАТО-ын интервенц нь Косово дахь хүчирхийллийг зогсоох тэргүүн зорилготой байсныг дурдах хэрэгтэй. Интервенц хийснээрээ НАТО өөрийн хил дээрх тогтворгүй байдлыг газар авахуулалгүй зогсоож, АНУ дэлхийн их гүрний үүргээ биелүүлсэн. Товчдоо Косовод хийсэн интервенцийн хувьд тогтвортой байдал, стратегийн байршил, өвөрмөц нөхцөл байдал зэрэг нь цугтаа байгалийн баялагтай дүйцэхүйц ач холбогдолтой байжээ.

Бусад интервенцүүдтэй адил Косово дахь интервенц нь бүс нутгийн эдийн засагт эерэг үр дагавар авчраагүй. Хэдийгээр бага багаар энх тайван, тогтвортой байдлыг тогтоосон боловч Косово дахь хууль бус, далд эдийн засагтай тэмцэхэд олон улсын хамтын нийгэмлэгээс төдийлөн амжилт олоогүй, тус улсад улс төрийн экстремизм оршсоор байгаа зэрэг нь Косово ба Балканы орнуудад цогц, суурь сайтай энх тайван, тогтвортой байдал тогтооход саад учруулсан хэвээр байна<sup>13</sup>.

### ДҮГНЭЛТ

Газрын тос улс буюу “petro-state” гэдэг нэршлийг абстракт маягаар олонтаа хэрэглэж, улс төрийн систем, нийгмийн бүтэц, эдийн засаг, соёл, шашны ялгаатай байдлыг үл харгалзан зөвхөн байгалийн баялаг эсвэл байгалийн хий их хэмжээгээр экспортолдог орнуудыг тус нэрээр тодорхойлж байна. Эдгээр орнуудад нийтлэг нэг төрлийн бэрхшээл байх бөгөөд тэр нь урт хугацааны эдийн засгийн хөгжлийн боломжоо эдийн засгийн гажуудал, эсвэл түүнээс үүдэх улс төр, нийгмийн сөрөг үзэгдэлд алдахгүй, сөрөг нөлөөнд нь оруулахгүй байхыг хангах явдал юм<sup>14</sup>. Үүнээс дүгнэж үзвэл байгалийн баялгаар баян улс орнууд онолын хувьд дээрх замаар олон улсын цаг үеийн байдалд зохицон нийцэхийг зорих бөгөөд ийм уян хатан чанар дутуу Ливи жишээтэй улс орнууд, өөрсдийн дотоод нөхцөлөөс болж цаашдын хүмүүнлэгийн интервенцийн гол бай болох магадлал өндөр байна.

Африк болон Латин Америкийн газрын баялаг ихтэй орнуудад хийсэн хүмүүнлэгийн интервенцээс болж ийм төрлийн ажиллагаа нь зөвхөн газрын баялаг тойрсон ашиг сонирхолд тулгуурлаж байна гэсэн дүгнэлтэд хүрч болох ч 1999 онд Косово, 1994 онд Гайти, 1992 онд Сомали, 1999 онд Зүүн Тиморт хийсэн хүмүүнлэгийн интервенцүүд ийм төрлийн ажиллагаа гагц эдийн засаг бус олон төрлийн мөргөлдөөнийг зохицуулах зорилгоор зарим тохиолдолд газар нутаг, газрын баялаг маш багатай улсуудад хэрэгжиж байдгийг харуулж байгаа юм.

Хүмүүнлэгийн интервенц болон байгалийн баялаг хоорондын тодорхой уялдаа холбоог өгүүллийн эхэнд дурдсанчлан нэлээд бүрхэг байгаа билээ. Гэвч хэрвээ

<sup>13</sup> Karen Baellentine and Jake Sherman., (2003). The Political Economy of Armed Conflict, Beyond Greed and Grievance. London: Lynne Rienner Publishers. Page 169

<sup>14</sup> Daniel Yergin., (2011). The Quest, Energy security and Remaking of the Modern World. New York: Penguin Press. Page 106

бид аливаа бүсийн тогтвортой байдал, аюулгүй байдал, аливаа улсын олон улсын нэр хүнд зэргийг баялаг гэж авч үзвэл хүмүүнлэгийн интервенц нь стратегийн хувьд ч, геополитикийн хувьд ч байгалийн баялагт хүрэх хамгийн шилдэг, ухаалаг арга хэрэгсэл болох юм. Хамгийн чухал нь байгалийн баялаг ба хүмүүнлэгийн интервенцийн хоорондын уялдаа холбоо нь баялгийн тухай бидний тодорхойлолт, ойлголтоос шалтгаалан янз бүрээр тогтохоор байна.

Хүмүүнлэгийн интервенцүүдийн үр дүнгүүд ч маргаантай байдаг. Учир нь интервенц хийсэн нутгуудад хөгжил дэвшил маш удаашралтай байгаа нь Африкийн жишээнээс тодорхой харагдаж байна. Одоогоор хэрэгжээд буй хүмүүнлэгийн интервенцүүд нь нэлээд ялгавартай хэрэгжиж ирсэн бөгөөд реалист судлаачийн хувьд тэдгээрийн гол зорилго нь хүмүүнлэгийн шалтгаанаас илүүтэй тухайн улсын ашиг сонирхолд голлон тулгуурласан буюу хүмүүнлэгийн интервенц хийх гол мотиваци нь байгалийн баялаг байжээ гэж хувьдаа үзэж байна. НҮБ-ын хүмүүнлэгийн интервенцийн санаачлага (ялангуяа энхийг байгуулах) нь олон улсын харилцаанд дэвшил болсон үйл явц боловч тус санаачилгын өнөөгийн хэрэгжилтийн хандлага нь улам бүр хүмүүст чиглэсэн хүмүүнлэгийн бус улс орнуудын ашиг сонирхол, байгалийн баялгаас үүдэлтэй болж байна. Дэлхийн байгалийн баялаг багасах тусам хүмүүнлэгийн интервенц нь улс орнуудын материаллаг ашиг сонирхлоос хамааралтай болох төлөвтэй байгаа нь ирээдүйд хүмүүнлэгийн интервенцийг тойрсон маргааныг улам бүр хурцатгахаар байна.

## НОМ ЗҮЙ

1. Daniel Yergin., (2011). The Quest Energy, Security, and the Remaking of the Modern World. New York: Penguin Press.
2. Christine Gray., (2004). International Law and the Use of Force. Oxford University Press.
3. Karen Ballentine and Jake Sherman., (2003). The Political Economy of Armed Conflict-Beyond Greed and Grievance. London: Lynne Rienner publishers.
4. Anthony F.Flang., (2003). Just Intervention. Georgetown University Press.
5. Michael T.Klare., (2002). Resource Wars. New York: Owl Books.
6. Daniel Lederman and William F.Maloney., (2003). Natural Resource, Neither Curse nor Destiny. Stanford University Press.

## Цахим эх сурвалж

1. Anthony Joseph., (2010). Humanitarian intervention; Pluralist and Solidarist view. [online] Available from: <http://www.anthonysjosephreport.com/2010/06/humanitarian-intervention-pluralists.html> [Accessed on 4 April 2012]
2. Mehmet Efe Biresselioglu, (2011). European Energy Security, Turkey's Future Role and Impact. [online] Palgrave Macmillan. Available from: <http://www.palgraveconnect.com.ezproxy.westminster.ac.uk/pc/doi/10.1057/9780230306851> [Accessed 2 April 2012].
3. Michael L.Ross, (2003). How Do Natural Resources Influence Civil War? Evidence from Thirteen Cases. [Online] Available from: <http://www.sscnet.ucla.edu/polisci/faculty/ross/IO%202004.pdf> [Accessed on 4 April 2012]
4. Blanchard, Christopher M., (2011). Libya: Unrest and U.S. Policy. [online] Congressional Research Service. Available from: <http://www.dtic.mil/cgi-bin/GetTRDoc?AD=ADA543510> [Accessed 3 April 2012].
5. Geroge Friedman., (2011). Libya, the West and the Narrative Democracy. [online] Available from: [http://www.afgazad.com/Zabanhaye-Eropaei/040111-Libya-the-West-and-the-Narrative-of-Democracy\[1\].pdf](http://www.afgazad.com/Zabanhaye-Eropaei/040111-Libya-the-West-and-the-Narrative-of-Democracy[1].pdf) [Accessed on 4 April 2012]. Page 4